

**Microsoft** [NASDAQ:MNFT]**Хөрөнгө оруулалтын хураангуй**

Nasdaq хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй Microsoft компанийн хувьцааны зорилтот ханшийг нийт 30 шинжээчдийн таамаглал дээр үндэслэн \$353.36 буюу ирээдүйд 30% өсөх төлөвтэй байгаа тул **ABAX** саналтай байна. Хөрөнгө оруулагчдын зүгээс өнөөгийн макро эдийн засагт үүсээд буй геополитикийн тодорхой бус байдал, төв банкны хатуу мөнгөний бодлого зэрэг хүчин зүйлсийг бодолцож байж шийдвэр гаргахыг зөвлөж байна.

Azure, Оффис 365, LinkedIn болон Сервэр үйлчилгээнүүдээс олсон орлого өссөнтэй холбоотойгоор компанийн борлуулалт 2021 онд өсжээ. Орос-Украины дайны улмаас ОХУ-тай бизнесийн бүх холбоогоо тасалсан тул борлуулалт \$110 сая буюу 2%-иар буурах төлөвтэй байна.

Санхүүгийн үзүүлэлт

II улирлын тайлан гарах огноо	2022.07.26
Нэгж хувьцаанд ногдох ашиг	\$2.31
Борлуулалт (2021 он)	\$168.1 тэрбум
Цэвэр ашиг (2021 он)	\$61.3 тэрбум
Цэвэр ашгийн маржин	36.45%

Ашгийн өсөлт болон харьцаа үзүүлэлт


Цэвэр ашгийн өсөлт (2021 он)	+39.52%
Цэвэр ашгийн өсөлт (ирэх 5 жил)	+15.00%
Борлуулалтын өсөлт (2021 он)	+17.53%
Үнэ ашгийн харьцаа (P/E)	25.80
Үнэ борлуулалтын харьцаа (P/S)	12.26
Үнэ эздийн өмчийн харьцаа (P/B)	13.11

ҮНЭТ ЦААСНЫ СУДАЛГАА
2022 оны 6 сарын 10

Зөвлөмж	ABAX
Зорилтот ханш	\$353.36
Хаалтын ханш	\$247.65
Өсөлт/Бууралт	+30%
52 д.х. ханш	\$246.44-\$349.67
33 үнэлгээ	\$2.019.5 тэрбум
Салбар	Програм хангамж

Эх сурвалж: Marketbeat

График 1. Хувьцааны ханш



Эх сурвалж: Investing.com

График 2. Хувьцааны ханшийн таамаглал



Эх сурвалж: CNN business

Компанийн тухай

АНУ-ын Вашингтон мужийн Рэдмонд хотод төвтэй Microsoft компани нь дэлхийн хамгийн том програм хангамж, технологийн хөгжүүлэгч, үйлдвэрлэгч компаниудын нэг бөгөөд одоогоор компьютерийн үйлдлийн системийн зах зээлийн 75.5%-ийг дангаараа эзэлж байна. Мөн тус компанийн Microsoft 365 хэрэглээний програм нь дэлхийд хамгийн их ашиглагддаг цөөн программуудын нэг.



COURTESY: MICROSOFT

Олон нийтийн үүлэн технологийн үйлчилгээ үзүүлэгч хоёрхон компанийн нэг нь тул ирээдүйд энэ салбартаа монопол болох боломж өндөр. Microsoft нь үйлдлийн систем, оффисын хэрэглээний программууд, сервер болон бизнесүүдэд зориулсан аппликейшн, видео тоглоом зэрэг салбаруудад үйл ажиллагаа явуулж байна. Мөн компьютер, таблет, видео тоглоомын консул зэрэг электроник төхөөрөмжүүдийг загварчилж худалдаанд гаргадаг.

Борлуулалтын орлогын задаргаа

Microsoft 2021 онд \$168.1 тэрбумын орлоготой ажилласан нь дараах 3 хэсгээс бүрдсэн:


1. Бүтээмж болон бизнес процесс
2. Ухаалаг үүлэн технологи
3. Хэрэглээний компьютер

Бүтээмж болон бизнес процессын салбарт Оффис 365, Teams, LinkedIn зэрэг үйлчилгээнүүд ордог ба нийт борлуулалтын 32.1%-ийг бүрдүүлжээ.

Ухаалаг үүлэн технологид Azure үүлэн үйлчилгээ ордог ба нийт борлуулалтын 35.7%-ийг дангаараа бүрдүүлсэн. Хэрэглээний компьютерын салбарт Windows үйлдлийн систем, Xbox, төхөөрөмжүүд болон Bing хайлтын систем багтдаг ба борлуулалтын 32.2%-ийг эзлэв.

Оффис 365-аас олсон орлого өмнөх жилийн мөн үеэс 16%, LinkedIn-ээс олсон орлого 34%, ухаалаг үүлэн технологийн үйлчилгээнээс олсон орлого 38.6% тус тус өсжээ.

График 3. Борлуулалтын орлого /тэрбум \$/



Хөрөнгө оруулах шалтгаан

Microsoft компани нь хэрэглээний компьютерын үйлдлийн системийн зах зээлийн ихэнх буюу 75.5%-ийг эзэлж байгаа нь асар том өрсөлдөх чадвартайг харуулж байна. Ялангуяа бизнесүүд Windows үйлдлийн системийг ашиглаж байгаа нь компанийн орлогод ихээхэн нөлөөлдөг.

Microsoft-ийн үүлэн технологийн үйлчилгээ болох Azure 60 гаруй бүс нутагт нэвтэрсэн ба эхний улирлын байдлаар борлуулалт 50%-иар өссөн нь энэ үйлчилгээг хэр хурдтай хөгжиж, хэрэглээнд нэвтэрч байгааг илтгэж байна.

Тоглоомын конселийн гурван том нийлүүлэгчдийн нэг нь Microsoft бөгөөд тэдний хөгжүүлдэг Xbox консулд зориулж Activision Blizzard-ийг \$69 тэрбумаар худалдан авах хэлэлцээр амжилттай болвол хэрэгчдийн тоогоо 400 орчим саяар нэмэх боломжтой.

График 4. Үйлдлийн системийн зах зээлд эзлэх хувь





График 5. Xbox game pass хэрэглэгчдийн тоо /сая/



Эрсдэл

Ухаалаг төхөөрөмжийн хөгжил нь гар утас, таблетын хэрэглээг нэмэгдүүлж, компьютерын хэрэглээнд заналхийлж байна. Ялангуяа OSX, Android зэрэг үйлдлийн системүүд тухайн зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, Windows-ийн хэрэглээг бууруулж байгаа нь Microsoft-ийн томоохон орлогын эх үүсвэрийг агшихад хүргэж магадгүй. Иймд Microsoft ухаалаг төхөөрөмжид зориулсан өрсөлдөхүйц үйлдлийн систем цаг алдалгүй гаргахгүй бол зах зээлээ алдах эрсдэлтэй байна.

Дээрээс нь үүлэн технологид Amazon, тоглоомын конселийн зах зээлд Sony Electronics-ийн Playstaion тэргүүлж байгаа нь Microsoft-ийн борлуулалтад томоохон дарамт болж байна.

**САНАМЖ:**

Энэхүү мэдээлэл нь Ард Секюритиз ҮЦК-иас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн шинжээчийн байр суурийг илэрхийлэх бөгөөд зах зээл болон бусад хүчин зүйлсийн нөлөөллөөр өөрчлөгдөх боломжтой юм. Бүх мэдээ, мэдээллүүд нь үүнд Ард Секюритиз ҮЦК-ийн эх сурвалж болгосон буюу гаргасан мэдээлэл үнэн бодит гэж үзсэн эх сурвалжаас авсан боловч нарийвчлал нь баталгаажаагүй болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөхтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу!

Бэлтгэсэн: Н. Цогбадрах

Хөрөнгө оруулалтын шинжээч

Утас: 9988 1656

И-мэйл: tsogbadrah.n@ardsecurities.com



2022 он

Ард Секюритиз ҮЦК бэлтгэв